

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2024 оны арванхоёрдугаар сарын 14

Чита

Энэхүү хамтран ажиллах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Төв аймгийн Эрдэнэ суман дахь Политехник коллежийн захирал **Ш.ОТГОНХҮҮ** (цаашид “**А тал**” гэх), Забайкальский тээврийн коллежийн улсын боловсролын байгууллагын захирал **С.Г. Батырев** (цаашид “**Б тал**” гэх), (цаашид хамтад нь “Талууд” гэх) нар харилцан тохиролцож энэхүү талт гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээний дагуу Төв аймгийн Эрдэнэ-Суман хотын Политехникийн коллеж, Забайкальский тээврийн коллежийн улсын боловсролын байгууллагын дүйцэхүйц сургалтын хөтөлбөр боловсруулж, багш, оюутны мэргэшлийг дээшлүүлэх юм. , мөн туршлага солилцох, багш, оюутан сургах, үйлдвэрлэлийн дадлага хийх, хөрөнгө оруулалт хийх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох богино хугацааны сургалт зохион байгуулах зэрэг талуудын харилцааг харилцан зохицуулна. гэрчилгээ.Хэлэлцэн тохирогч талууд үйл ажиллагаандаа энэхүү гэрээ, Монгол Улс, ОХУ-ын хууль тогтоомж болон талуудын бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг дагаж мөрдөх үүрэгтэй.
- 1.2. Гэрээний гүйцэтгэл хамтын ажиллагааг бататгахын төлөө харилцан тусалж дэмжин, гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар зохих ёсоор гүйцэтгэж хамтран ажиллах, харилцан туслалцах зарчмыг мөрдлөг болгоно.
- 1.3. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс хойш 15 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

2. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. “А” тал нь хамтын ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сургалтын орчин бааз бүрдүүлэлтийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих,
- 2.2. “Б тал” нь хамтын ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сургалтын орчин бааз бүрдүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалт санхүүжилтийн эх үүсвэрийг хангах
- 2.3. Гэрээнд заагдсан ажил үргийг гүйцэтгэх үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандарт шаардлагыг ханган ажиллах үүрэгтэй.

3. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 3.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 3.2. Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг 5 жил тутамд дүгнэж, үр дүнг тооцно.

4. БУСАД ЗҮЙЛ

- 4.1. Талууд харилцан зөвшилцсэний үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажина. Тус гэрээний нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 4.2. Гэрээг дараах тохиолдолд цуцалж болно.
 - 4.2.1. Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачилгаар;
 - 4.2.2. Талууд харилцан тохиролцсон бол;
- 4.3. Тус гэрээний хугацааг цуцлахдаа нөгөө талдаа 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдсэн байна.
- 4.4. Энэхүү гэрээний хугацаа дуусгавар болох мөн гэрээ цуцлагдсанаар талуудад олгогдсон эрх, үүрэг мөн дуусгавар болно.
- 4.5. Талуудын эзэмшигч, удирдлага, бүтэц өөрчлөгдсөн нь гэрээг дуусгавар болгох, цуцлах үндэслэл болохгүй.
- 4.6. Гэрээний хугацаа дуусаж цаашид сунгагдахгүй болсон, эсхүл аль нэг тал эрх зүйн чадамжгүйд тооцогдсон бол гэрээ дуусгавар болсонд тооцогдоно.
- 4.7. Гэрээг 3 /гурван/ хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр хүчин төгөлдөр байна.
- 4.8. Талууд гэрээнд тусгаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улс, ОХУ-ын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй.

5. ТАЛУУДЫН ХАЯГ

“А” ТАЛ:

Хаяг: Төв аймгийн Эрдэнэ суман дахь Политехник колледж
Утас: 99745616



“Б” ТАЛ:

Хаяг: г.Чита, ул. Гайдара, 4
Утас: 8(3022)-21-71-40

